

**ӨВӨР МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ТҮҮХЭН ДЭЭРХИ МОНГОЛЫН ӨӨРТӨӨ
ЗАСАХ УЛСЫН ТҮҮХТ АЧ ХОЛБОГДЛЫН ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ**

Ганбагана¹

Эхлэл

1931 онд Манж гүрэн задарсны дараа Японы Квантуны арми Хятадын зүүн хойд орныг хүчээр эзэлж улмаар Мануул засаг - Манж улсыг байгуулснаас Өвөр Монголын зүүн хэсэг аажмаар Японы эрхшээлд оржээ. Харин баруун хэсэгт Дэмчигдонров вангийн удирдсан Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн өрнөсөн байна. Гэвч түүний хөгжлийн зам нь тийм шулуун дардан байгаагүй юм. Эхэндээ Дундад иргэн улсын засгийн газрын эсэргүүцэлтэй тулгарч байсан бол сүүлдээ Японтой хамтран түүний дэмжлэгийг хүлээх болжээ.

Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөний оргил нь 1941 оны 8 сард Монголын өөртөө засах улсыг байгуулсан явдал болно. Гэвч өнгөрсөн судалгаанд энэ талаар бараг дурдагддаггүй. Харин түүнээс хоёр жилийн өмнө (1939 оны 9 сард) байгуулагдсан Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар нь л чухалчилагдан судлагдаж заримдаа хоёрдугаар “Манж улс” хэмээн үнэлэгдэж байсан удаа буй. Үүний гол шалтгаан нь юу вэ гэвэл Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсан нь үнэндээ Квантуны армийн санаачлага байсан бөгөөд тухайн үед хэдийгээр Дэмчигдонров ван эсэргүүцэж байсан ч Японы талын хүнд шахалтаас болж арга буюу эцэстээ хүлээн зөвшөөрсөн болов уу.

Гэтэл орчин үеийн Өвөр Монголын түүхийг судлахдаа Монголын өөртөө засах улсын тухай төдий л анхаарч үздэггүй нь чухам юуг харуулж байна вэ гэвэл тухайн үеийн Өвөр монголчуудын гүйцэтгэсэн түүхт үйл явдлыг үгүйсгэх зорилготойгоос тэр юм. Тухайн үед Өвөр монголчуудын хүчин чармайлт байсны ачаар сая Монголын өөртөө засах улс байгуулагдсан гэж хэлж болно. Ялангуяа бид Монголын өөртөө засах улсын үеийн Монголыг мандуулах зөвлөл болоод түүний үйл ажиллагааг нарийвчлан ажиглавал монгол орны сэргэн хөгжиж байсан байдал ч багагүй харагдана. Гэтэл өнгөрсөн судалгаанд Монголын өөртөө засах улсыг хүргэл анхаарч судлаагүй байсан болохоор түүний доорхи байгууллага болох Монголыг мандуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаар бараг хөндөгдөөгүй билээ. Тухайн үеийн Өвөр Монголын түүхийн олон асуудал нь Монгол хязгаарын засгийн газар гэдэг нэгэн ерөнхий дээрээ балархай нэр томъёон дор дурдагдсаар ирсэн байна. Иймээс энд би Монголын өөртөө засах улсын тухай авч үзэх болно.

1. Akita International University

Ганбагана

Нэг. Японы Өвөр Монгол дахь төрийн бодлого ба Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсан нь

Олны мэдэхээр Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн нь Дэмчигдонров вангийн удирдлага доор 1933 онд эхэлсэн байж билээ. Тус хөдөлгөөн Монголын засгийн явдлын зөвлөл (1934 оны 4 сар), Монгол цэргийн засгийн газар (1936 оны 5 сар), Монголын чуулганыг холбож өөртөө засах засгийн газар (1937 оны 10 сар), Монгол хязгаарын холбоот зөвлөл (1937 оны 11 сар) зэрэг нэрийн дор үйл ажиллагаагаа явуулсаар 1939 оны 9 сард Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газрыг байгуулахаар болжээ. Гэтэл үнэндээ энэ хүртэл туулж ирсэн зам нь энхэл донхол бөгөөд өнгөн дээрээ Японтой хоршиж байгаа шиг харагдаж байсан ч үнэндээ зөрчил мөргөлдөөн ч бас багагүй байжээ. Ялангуяа Дундад улс Японы хооронд дайн эхэлсний дараа Дэмчигдонров ван болоод Квантуны армийн зөрчил улам ил тод болсон байна. Тухайлбал, тухайн үед Дэмчигдонров ван Квантуны армийн дэмжлэгээр Сүй Юан хотыг (Хөх хот) эзэлсний дараа үнэндээ тусгаар тогтносон Монголын засгийн газрыг байгуулахаар зорьж байжээ. Гэтэл энэ төлөвлөгөө нь Канаи Шижигаар төлөөлүүлсэн Квантуны армийн эсэргүүцэлтэй тулгарсан төдийгүй Квантуны арми яг Дэмчигдонров вангийн үзлийн эсрэгээр тухайн үед нэгэнт байгуулагдаад байсан Хятадын өөр хоёр мануул засагтай нийлүүлж нэгэн шинэ засгийн газар байгуулахыг зорьж байжээ. Ийнхүү Дэмчигдонров ван болоод Квантуны армийн зөрчил хурцадсан байна.

Иймээс Дэмчигдонров ван Японы засгийн газрын удирдах хүмүүстэй Өвөр Монголын асуудлыг шууд ярилцахын тулд 1938 оны намар Японд айлчлан очсон байна. Тэрээр Токиод очсоны дараа Японы улс төрийн томчуудтай уулзаж Өвөр Монголын асуудлыг зөвлөхөөр Хуурай замын цэргийн яамны сайд Итагаки Сайширод өөрийн боловсруулсан хоёр зүйлийн улс байгуулах төлөвлөгөөгөө танилцуулсан байна. Түүний эхний төлөвлөгөө нь Өвөр Монголын баруун хэсэг орныг л хамаарч байсан бол нөгөө төлөвлөгөө нь зохих хэмжээгээр Квантуны армийн санаанд нийцүүлж дээр дурдсан Хятадын хоёр орныг ч багтааж байжээ.² Гэвч түүний энэ хоёр төлөвлөгөөний аль нь ч биелэгдэж чадаагүй бөгөөд эцэст нь Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсан байна. Үүнтэй холбогдуулан дурьдвал үнэндээ тухайн үед Японы талынхан ч догроо үзэл бодлоороо нэгдмэл байгаагүй байна. Олон зүйлийн өөр санал, төлөвлөгөө гарч байсныг Японы архивын материалуудаас үзэж болно. Японы гадаад явдлын яамны архивт “Өвөр монголийн тусгаар тогтнолын тухай”³ болоод “Монголын төрийн бодлогын хөтөлбөр”⁴ гэх хоёр зүйлийн материал хадгалагдаж буй. Өмнөх нь Өвөр монголийн тусгаар тогтнолыг дэмжиж байсан бол хоёрдох нь эсэргүүцсэн байжээ.

Хоёр. Ван Жин Вэйгийн засгийн газар байгуулагдсан ба түүний Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн нөлөө

Дундад-Японы дайн өргөжихийн хирээр Японы Хятадын талаарх төрийн бодлогод өөрчлөлт гарч эхэлжээ. Тэд нэг талаар дайнаа үргэлжлүүлэхийн сацуу нөгөө талаар Хятадын

2. Морн Хисао 『徳王自伝』(Дэ вангийн намтар: Монголын сэргэн мандалтын мөрөөдөл ба бүтэлгүйтэл), т 219-220

3. 「内蒙古独立ニ関スル件」(Өвөр Монголын тусгаар тогтнолын тухай), Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs:A.1.1

4. 「対蒙政策要綱」(Монголын төрийн тодлогын гөтөлбөр), Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs:A.1.1

Ганбагана

засгийн газрыг хагаралдуулах идэвхитэй бодлого явуулснаас эцэстээ Дундад иргэн улсын засгийн газрын дотор хагарал гарсан байна. Тэгээд Ван Жин Вэй тэргүүтэй Японы талыг баримтлагч бүлэг хүмүүс тухайн үед нэгэнт Японд эзлэгдээд байсан Нанжин хотод оргон очиж тэнд Япончуудтай хамтран нэгэн шинэ засгийн газрыг байгуулж эхэлсэн байна. Ван Жин Вэй нь Дундад иргэн улсын засгийн газрын чухал нөлөөтэй улс төрч бөгөөд Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн үүссэн үеэс эхлэн монголын улс төрд оролцох болжээ. Тэрээр тухайн үед хэдийгээр өөрийн эх Дундад иргэн улсаасаа тэрсэлж харийн дайсантай хамтарч явсан ч Өвөр Монголын тусгаар тогтнолын асуудал дээр хатуу чанга байр суурь баримтлан салж гарахыг нь эрс эсэргүүцэж байжээ. Тиймээс Японы талынхан түүний дэмжлэгийг авахын тулд энэ шаардлагыг нь арга буюу хүлээн авч, Өвөр Монголд явуулж ирсэн төрийн бодлогоо өөрчлөөд, тусгаар тогтнолыг нь дэмжихээс татгалзаж эхэлсэн төдийгүй эсэргүүцэх болжээ. Жишээлбэл, 1939 оны 11 сарын 30-нд Япончууд Ван Жин Вэйтэй гэрээ байгуулахдаа Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар дахь Хятадын засгийн газрын эзэнт гүрний эрхийг мэдэрсэн байна. Дараа нь 1940 оны 1 сард “Чиндоугийн хурал”-ыг зохиан байгуулж, энэ хурал дээр Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар нь Ван Жин Вэйгийн засгийн газарт харьяалагдахыг энэ хоёр засгийн хоорондох гэрээгээр очиж дахин мэдрүүлжээ.⁵ Гэвч Дэмчигдонров ван тухайн үед шинээр байгуулагдагсан энэх Ван Жин Вэйгийн засгийн газрыг ерөөсөө хүлээн зөвшөөрч байгаагүй. Тийм учраас 1940 оны 4 сард Ван Жин Вэй Чуулалт хаалгаар айлчлан очиход Дэмчигдонров ван хүлээж авч уулзахаас таггалзаж түүнийг гутаасан байна.

Товчлоод хэлбэл Ван Жин Вэйгийн засгийн газар байгуулагдсан нь Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөнд идэвхитэй бус үйлдэл үзүүлсэн байна.⁶

Гурав. Дэмчигдонров вангийн хоёр дахь удаагийн Япон дахь айлчлал ба Монголын өөртөө засах улсын байгуулагдсан нь

Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсан явдал нь хэрэг дээрээ Өвөр Монголын тусгаар тогтнолын асуудлыг үгүйсгэсэн явдал байснаас монголчуудын Японд хандах сэтгэл нь хөрж эхэлжээ. Үүний тухай Мацүзаки Юу номондоо “Өнгөрсөнд монголчууд биднийг ах дүүгээ шиг үзэж байсан бол өнөөдрийн монголчууд биднийг өстөн дайснаа шиг үзэх болжээ” гэж бичсэн байж.⁷ Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсаны дараа Дэмчигдонров ван Дундад иргэн улсын засгийн газартай дахин нууцаар харилцаж эхэлсэн учир нь ч үүнийг харуулж байгаа юм. Ногоо талаар Японы монгол дахь төрийн бодлогын хувиралт нь эсэргээрээ монголчуудын үндэсний үзлийг улам хөгжөөсөн байж. Монголын тусгаар тогтнолыг намынхаа гол хөтөлбөрөө болгосон монгол залуучуудын намын нууц ажиллагаа тухайн үед залуучуудын дунд их өрнөж байжээ.⁸

Тухайлбал Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсаны дараа Өвөр Монголын улс төрийн байдал явах тутам хүнд ночтой болоод иржээ. Тиймээс энэх байдлыг өөрчлөхийн төлөө Дэмчигдонров ван 1941 оны 2 сард хоёрдахь удаагийн Япон дахь айлчлалгаа хийсэн байна. Энэ удаагийн айлчлалтаар тэр өөрийн гараараа бичсэн “Монгол улсыг байгуулахыг хурдатгах төсөл” –өө Японы ерөнхий сайд Кунуай Фумимаруд шууд гардуулахын

5. Sechin Jagchid, *The Last Mongol Prince: The Life and Times of Demchugdongrob, 1902-1966*, т228-229

6. Ганбагана 「汪兆銘と内モンゴル自治運動」 (Ван Жо Мин ба Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн), “Японы монгол судалгааны нийгэмлэгийн сэтгүүл”, № 35, 2005 оны 3 сар, т17-28

7. Мацүзаки Юу 「興蒙推進要綱」 (Монголыг сэргээн мандуулах готолбор), т11-17

8. 「蒙古独立運動ヲ目的トスル「蒙古青年結盟党」ノ策動ニ関スル件」 (Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнөөр зорилгоо болгоосон монгол залуучуудын намын тухай). Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs: A.6.1

Ганбагана

дагуу бүрэн эрхт тусгаар тогтносон улс байгуулах нь боломжгүй бол адагтаа Монголын өөртөө засах улсыг байгуулахыг хүсэн эрэмжилсэн байна.⁹

Гэтэл монголын тусгаар тогтнолыг зөвшөөрвөл Ван Жин Вэйгийн засгийн газартай гадаад харилцааны асуудал үүсэх байсан учраас Японы талынхан Дэмчигдонров вангийн энэ удаагийн айлчлалд туйлын идэвхитэй бус байдлаар хандсан байж Японы ерөнхий сайд ч өвчилснөөр шалтаглаж уулзахаас татгалзаж байв. Нөгөө талаар Дэмчигдонров вангийн шаардлагыг зөвшөөрөхгүй бол монголчуудын сэтгэлийг бүрмөсөн алдах гэсэн “dilemma” ч оршиж байв. Энэ тухай Японы монголд суугаа консулын газрынхан Японы гадаад явдлын яамандаа хийсэн мэдүүлэлтдээ: “Дэмчигдонровын санааг хангахгүй бол монголчуудын сэтгэлийг олоход бэрх” гэж ярьсан байдаг.¹⁰ Тэгээд хамгийн сүүлд нь Японы засгийн газрынхан Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар нь нэрээ Монголын өөртөө засах улс гэж халахыг арга бус зөвшөөрсөн байна. Гэвч гадаад харилцааны асуудал үүсэхээс зайлсхийж гадаадад угийн нэрээ хэрэглэхийг шаардсан байв. Ингээд 1941 оны 8 сарын 4-нд Монголын өөртөө засах улс нь байгуулагджээ. Монголын өөртөө засах улсын нэр нь Японоор хэдийгээр “улс” гэдэг үгийг хэрэглээгүй, харин “хуу” гэдэг үгээр илтгэж байсан ч монголоор “улс” гэж нэрлэж байсан болохоор тухайн үеийн монголчууд улс байгуулахын анхны шат хэмээн үзэж баяртайгаар хүлээж авсан байна.

Дорөв. Өөртөө засах эрхийн өргөжил ба монгол хошуудыг сэргээн мандуулах үйлс

Дээр ярьсан шигээр Дэмчигдонров ван тэргүүтэй монголчуудын чанга шаардлага болоод Японы талын эвлэлээс болж Монголын өөртөө засах улс байгуулагдсан байна. Тухайн үед Хятадын нэг бүлэг сэхээтнүүд “энэ нь Хятадаас салж гарах тэмдэг байх” гэж сэжиглэлтэй нүдээр харж байсан бол олонхи монголчууд харин “Монголын тусгаар тогтнолын совин”, “Их Монголыг бүтээн байгуулахын эхлэл” хэмээн үзэж байв.¹¹

Монголын өөртөө засах улс байгуулагдсаны дараа Японы талынхан монголчуудын сэтгэлийг олохын төлөө Дэмчигдонров вантай эсэргүүцэлдээд байдаг монголд суугаа цэргийн штабын дарга Уубаши Кумоуг монголоос шилжүүлж аваачсан байна. Бас 1941 оны 11 сарт Дэмчигдонровын хүсэлтээр түүнтэй дайсагнасаар ирсэн Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газрын хамгийн дээд зөвлөгч Канаи Шоэжиг солиод оронд нь монголчуудад найрсаг сэтгэлтэй байдаг Уухаши Чиүичиг томилсон байна. Гэтэл Уухаши Чиүичи нь монголчуудад сайн хандаж харин монголд суугаа японы цэргийнхэнтэй эв эээр таарамжгүй байсан болохоор дэмий удалгүй цэргийн талынхан түүнийг аргалж байгаад Японд нь буцаалгажээ. Түүнээс хойш Японы засгийн газар дахин хамгийн дээд зөвлөгч томилоогүй. Ингээд Дэмчигдонровын байр суурь эрх тушаал их хэмжээгээр нэмэгдсэн байна.

Загчид Сэцэний дурсамжийг үндэслэвэл тухайн үед монгол орны засаг захиргааны эрх нь бараг бүр монголчуудын гарт байж Японы зөвлөгч нар ер нь гар дүрдэггүй байсан гэж бичиж байжээ. Үүнийг гэрчилж болмоор тэмдэглэл Японы гадаад явдлын яамны архивт ч хадгалагдаж байна. Монголын өөртөө засах улсын үед Дэмчигдонровын авсан гол төрийн бодлого гэвэл “Хятад Монгол салган эзэгнэх” арга байж Хятад орон болоод Хотон орныг дотоод явдлын яаманд тушаан өгч хамааруулж байсан бол монгол оронтой холбоотой бүхий л засаг захиргааны явдлуудыг Монголыг мандуулах зөвлөлөөр эзэгнүүлж байжээ. Монголыг мандуулах зөвлөл нь биеэ даасан засаг захиргааны байгууламж байж монгол орны бүтээн

9. 「蒙古建国促進案(徳王起草)」(Монгол улсыг байгуулахыг хуралгах төсөл), Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs: LD30300
10. Sechin Jagchid, *The Last Mongol Prince: The Life and Times of Demchugdongrob, 1902-1966*, т248
11. 「蒙古自治邦發布ニ対スル反撃ニ関スル件」(Монголын өөртөө засах улс байгуулагдсаныг нийтэлсэн нөлөөний тухай), The National Institute for Defense Studies, Ministry of Defense, Rekushimitsu Dainikki, No.42,1/2, 1941

Ганбагана


байгуулалтын талаар олон арвин бодит ажил хийж яг л нэг цомхотгосон монгол засгийн үйлдлийг бадруулж байсан гэж хэлж болно. Түүний гол ажил нь “аж ахуйн бүтээн байгуулалт, сурган хүмүүжлийн түгээмэлжүүлэлт, ардын амьдралын дээшлүүлэлт” зэрэг гурван талыг хамарсан байдаг. Яриангүй тухайн цаг үе нь дайн дажнаар дүүрсэн үймээн дэвжээнтэй цаг үе байснаас монголыг сэргээн мандуулах үйлс нь тийм их сүр далайцтай явагдаж чадаагүй. зөвхөн дөрвөн жил л үргэлжлээд дайн дуусхын хамт зогссон байна. Гэвч монголоо сэргээн мандуулахаар гол зорилго болгосон Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн нь энд хүрээд эцэстээ зохих хэмжээний амжилт гаргаж чадсан байна гэж үзэж болох юм.¹²

ДҮГНЭЛТ

Хураангуйлаад хэлбэл, Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдсаны дараа Квантуны армийн ноёрхол чангарсан нь үнэн. Өнгөрсний судлаачдын олонхи нь энэ асуудлыг хэт анхаарснаас болж хойнохыг нь харин нарийн шинжиж чадаагүй байж зөвхөн ганц талын дүгнэлт хийсээр ирсэн байна. Гэтэл бид Монголын өөртөө засах улсын байгуулагдсан явцыг нарийн ажиглавал Японы талын найр тавьсан зүйл ч тодхон харагдана. Өөрөөр хэлбэл, Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар нь Японы санаачлагаар байгуулагдсан гэж хэлбэл Монголын өөртөө засах улс нь эл талын санааг харуулж чадсан байжээ гэж хэлж болох байх. Бас нэг дурдууштай зүйл нь Монголын өөртөө засах улсын үед монголчууд үндсэндээ өөртөө засах эрхийг тэмцэн олж чадсанаар барахгүй, Монголыг мандуулах зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжиж Монгол орон ч сэргэн мандах замдаа ороод байсан гэж хэлж болно. Гэвч тэр нь цаг төрийн эргэлтээс болж удаан үргэлжилж чадаагүй ч тэрхүү түүхэн хандаш нь Өвөр Монголын орчин үеийн түүхийг судлахад шинэ нэгэн түүхэн ойлголтыг хангаж өгөх байх хэмээн үзэж байна.

12. Ганбагана 「内モンゴル自治運動における興蒙委員会の役割について」 (Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн монголыг мандуулах зөвлөлийн хувь нэмэр). “Хэл, бус нутгийн судлал”. № 13, 2007 оны 3 сар, т87-103

Ганбатана



Монголын өөртөө засах улсын нутаг дэвсгэр

極秘

其平... 立憲... 各... 今... 本...

一、方...

其平... 立憲... 各... 今... 本...

НОМ ЗҮЙ

「内蒙古独立ニ関スル件」(Өвөр Монголын тусгаар тогтнолын тухай). Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs:A.1.1

「対蒙政策要綱」(Монголын төрийн бодлогын гөтөлбөр). Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs:A.1.1

「蒙古独立運動ヲ目的トスル「蒙古青年結盟党」ノ策動ニ関スル件」(Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнөөр зорилгоо болгоосон монгол залуучуудын намын тухай), Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs:A.6.1

「蒙古建国促進案」(Монгол улсыг байгуулахыг хурдатгах төсөл). Diplomatic Archive of the Ministry of Foreign Affairs, Records of the Ministry of Foreign Affairs: L・3・3・0

「蒙古自治邦発布ニ対スル反撃ニ関スル件」(Монголын өөртөө засах улс байгуулагдсаныг нийтэлсэн нөлөөний тухай). The National Institute for Defense Studies, Document Files of the Ministry of the Army, Rekushimitsu Dainikki, No.42,1/2, 1941

Sechin Jagchid, *The Last Mongol Prince: The Life and Times of Demchugdongrob, 1902-66*, Center for East Asian Studies Western Washington University, 1999

森久男「徳王自伝」(Мори Хисао. Дэ вангийн намтар: Монголын сэргэн мандалтын мөрөөдөл ба бүтэлгүйтэл). Иванами шётэн, 1994 он

松崎陽「興蒙推進要綱」(Мацүзаки Юу. Монголыг сэргээн мандуулах гөтөлбөр). Хөх хотын Монгол судлалын хороо, 1941 он

ガンバガナ「汪兆銘と内モンゴル自治運動」・『日本モンゴル学会紀要』(Ганбагана, Ван Жо Мин ба Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөн, "Японы монгол судалгааны нийгэмлэгийн сэтгүүл"). № 35, 2005 оны 3 сар, т17-28

ガンバガナ「内モンゴル自治運動における興蒙委員会の役割について」『言語・地域文化研究』(Ганбагана, Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн монголыг мандуулах зөвлөлийн хувь нэмэр), "Хэл, бүс нутгийн судлал". № 13, 2007 оны 3 сар, т87-103